ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ

БАТЛАВ:

ХААИС-ИЙН РЕКТОР _____ Б.БААСАНСҮХ

ЭЗБС-ийн ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:	*Эдийн засаг, бизнесийн сургуулийн хичээлийн байрны засварын ажил*
Тендер шалгаруулалтын дугаар:	*ХААИС/20250101070*

2025 он

БАТЛАВ: ХААИС-ИЙН РЕКТОР Б.БААСАНСҮХ

ЭЗБС-ийн ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь захиалагч болон ашиглагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдаа холбоотой ажиллана.

Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм 1-р хэсэг, 2-р хэсэг Ерөнхий шаардлага БНбД 12.03.04, БНбД 12.04.06 –ийг дагаж мөрдөн ажиллана.

Ажлын тоо хэмжээ дэх ажлыг БНбД-ийн дагуу технологийн горимыг баримтлан гүйцэтгэж, ажлын үе шат бүрийг захиалагчийн хяналтаар баталгаажуулан дараагийн ажил үргэлжлүүлэн гүйцэтгэх зөвшөөрлийг авч ажиллах бөгөөд ажил тус бүрийг фото зургаар баримтжуулан далд ажлыг гүйцэтгэлийн зургаар баталгаажуулна.

Засварын ажлыг календарчилсан төлөвлөгөөний дагуу хийнэ.

Барилгын засварын ажлын явцад гарсан хог хаягдлыг зөөвөрлөн, төвлөрсөн хогийн цэгт хаяна.

1. АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА

Барилгын ажилд ашиглагдах материалууд нь олон улсын болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай, хүний эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлсэн байх;

Барилгын материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтэт технологийн шаардлагад нийцсэн байх;

Барилгын материалууд нь тохирлын гэрчилгээтэй, **хананы хавтан,хивсэнцэрийн "дээж** авчирах

Барилгын ажилд хэрэглэгдэх аливаа материалуудыг барилгын талбайд их хэмжээгээр татахаас өмнө материалын дээжийг захиалагчид үзүүлж зөвшилцөх зарчмаар хамтран ажиллах бөгөөд захиалагчтай зөвшилцөлгүйгээр стандартад нийцээгүй, буруу, чанаргүй материал ажилд ашигласан тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлыг гүйцэтгэгч хариуцах;

2. БУСАД ШААРДЛАГА

Гүйцэтгэгч тодорхой шалтгааны улмаас засварын ажлын материалыг өөрчлөх тохиолдолд захиалагч байгууллагад бичгээр хүсэлт гаргах бөгөөд хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор албан бичгээр хариу өгөөгүй тохиолдолд төсөвт тусгасан материалаар гүйцэтгэнэ.

Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засварын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах болно.

3. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Тендерт оролцогч нь үнийн санал ирүүлэхээс өмнө барилга засварын ажилтай газар дээр нь танилцаж, ажлын хэмжилтийг тулган баталгаажуулах бөгөөд төсвийн тоо хэмжээнд зохиогчийн хяналтын зардал, төсвийн тоо хэмжээнд тусгагдаагүй технологийн дагуу зайлшгүй хийгдэх ажлыг ажлын тоо хэмжээнд оруулан тооцох бөгөөд энэ нь тендерийн анхны үнийг өсгөх шалтгаан болохгүй.

Засварын ажлыг хуанлийн 60 хоногт хийж гүйцэтгэнэ.

ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД

1: Цонхны ажил

- **Гүйцэтгэх ажил:**
  - Хуучин цонхыг авах
  - Хог хаягдлыг зайлуулах
  - Шинэ цонх угсрах, бүрэн бүтэн, завсар зай гаргалгүй хүлээлгэж өгөх
- **Материалын стандарт:** 3 давхар шилтэй, Монгол улсын стандартуудыг хангасан байх.

2: Шалны ажил (Бетон суурь)

- **Гүйцэтгэх ажил:**
  - Хуучин шалыг хуулах
  - Хог хаягдлыг зайлуулах
  - Бетон суурь шалыг цутгах
  - Шалыг сэнсдэж өнгөлж, модуль хивсэнцэр дэвсэхэд бэлэн болгох
- **Материалын стандарт:** Стандартын шаардлага хангасан цемент, бетон байх. Гадаргуу нь маш гөлгөр, тэгш байх ёстой.

3: Цахилгааны монтаж

- **Гүйцэтгэх ажил:**
  - Хуучин монтаж авах

- Шинэ цахилгааны монтаж хийх
- Гэрэл, розетка, унтраалга суурилуулах

- **Материалын стандарт:** Оффисын зориулалттай гэрэл, розетка, зэс утас.

4: Интернэтийн монтаж

- **Гүйцэтгэх ажил:**
  - Хуучин кабелийг авах
  - Шинэ сүлжээний кабель татах
  - Wi-Fi роутер суурилуулах.
- **Материалын стандарт:** оффисын зориулалттай роутер, кабель.

5: Дотоод засал

- **Гүйцэтгэх ажил:**
  - Таазыг тэгшилж, эмульсдэх
  - Хананд хавтан суурилуулах
  - Хивсэнцэр шал угсрах
  - Шилэн хана, хаалга угсрах
  - Оффисын роллер хөшиг тогтоох
- **Материалын стандарт:**
  - **Хивсэнцэр:** Оффисын зориулалтын, элэгдэлд тэсвэртэй (commercial grade), 50х50см хэмжээтэй, CRI эсвэл CE сертификат эсхүл аль нэг нь байх, зузаан нь 6-+1 мм, жин нь 550 гр/м2-аас дээш, нейлон эсвэл полипропилен материалаар хийсэн, PVC суурьтай байна.
  - **Хананы хавтан** - Цохилтод тэсвэртэй 7,5-8 мм, тохирлын гэрчилгээ
  - **Шил** - 10-12мм, стандартын нугастай шилэн хаалга,
  - **Хөшиг**- оффисын роллер хөшиг.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Цонхны ажил	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин цонх буулгах	м.кв	140
2	Шинэ цонх угсрах	м.кв	140
№	**Шалны ажил**	**Нэгж**	**Тоо хэмжээ**
1	Хуучин шал хуулах	м.кв	640
2	Бетон суурь шал цутгах	м.кв	640
3	Бетон шалны гадаргууг сэнсдэж өнгөлөх	м.кв	640
№	**Цахилгааны монтаж**	**Нэгж**	**Тоо хэмжээ**
1	Цахилгааны шугам, кабель татах	м.кв	576
2	Гэрэлтүүлэг суурилуулах	ш	64
3	Розетка суурилуулах	ш	107

4	Унтраалга суурилуулах	ш	20
№	**Интернэтийн монтаж**	**Нэгж**	**Тоо хэмжээ**
1	Хуучин интернэтийн сүлжээг авах	м.кв	576
2	Шинэ интернэтийн сүлжээний кабель татах	м.кв	576
3	Сүлжээний ханын оролт (LAN port) суурилуулах	цэг	11
4	Роутер суурилуулж тохируулах	ш	11
№	**Дотоод засал**	**Нэгж**	**Тоо хэмжээ**
1	Модуль хивсэнцэр шал угсрах	м.кв	600
2	Таазны гадаргууг тэгшлэх (замаск)	м.кв	600
3	Таазанд эмульсэн будаг хийх	м.кв	600
4	Хана, цонхны хавтан суурилуулах	м.кв	980
5	Шилэн хана, хаалга угсрах	м.кв	312
6	Оффисын роллер хөшиг тогтоох	м.кв	145

Тендерт ирүүлэх материал:

- Тухайн багц ажлыг гүйцэтгэх үе шатны нарийвчилсан график
- Ашиглах материалын стандарт, техникийн үзүүлэлтүүд
- Ажлын талбайтай танилцсан зураг
- Төсвийн нарийвчилсан тооцоо
- Ханын хавтан ба шалны дэвсгэр материалын дээж

БОЛОВСРУУЛСАН:

ХААИС-ИЙН
ЭЗБС-ИЙН ЗАХИРАЛ Т.ЭРДЭНЭЧУЛУУН